



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2025/075/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: <a href="mailto:atartsetsegm@audit.gov.mn">atartsetsegm@audit.gov.mn</a> Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: <a href="mailto:munkhboldbo@audit.gov.mn">munkhboldbo@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.02.23 № 13.

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ДАРГА Ж.ОЧИР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 262 дугаар тогтоолоор 227,994.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, ХХААХҮС-ын 2024 оны А/574 дүгээр тушаалаар 18,382.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 13,500.0 мянган төгрөгийн принтер, камер суурилуулан нийт 259,876.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтээр аймгийн зарим сумдад өвөлжилт хүндэрч, зудад өртсөн малчдад тусламж, үйлчилгээ үзүүлэх, зам даваа онгойлгож засах, үхсэн мал, амьтадын сэг зэм устгах зэрэг ажлуудад 77,167.5 мянган төгрөгийг, "Хүргэлт-V" арга хэмжээнд 33,097.5

8225020036

мянган төгрөгийг, өвс, тэжээл бэлтгэхэд 258,500.0 мянган төгрөгийг, газар тариалангийн чиглэлээр ухаалаг программ сургалт хийхэд 19,000.0 мянган төгрөг, сэлбэг, тоног төхөөрөмжид 19,500.0 мянган төгрөгийг, зүлэг, үр, мод суулгац, 50,300.0 мянган төгрөгийг, ХХОАТ-т 16,604.0 мянган төгрөгийг, албан томилолтод 2,676.8 мянган төгрөгийг, нийт 476,845.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 4 хөтөлбөр, 9 зорилт, 35 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас ажлын хэсэг 97.9 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>188,052,387.4</u></b>	<b><u>476,441,467.8</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,769,809.3	8,892,904.0
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	8,892,904.0
3351	Байгууллагаас авах авлага	-	8,892,904.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	181,378,578.0	209,048,563.8
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	160,378,578.0	160,048,563.8
35410	Бичиг хэргийн материал	4,930,330.0	4,440,880.0
35420	Аж ахуйн материал	147,229,832.0	154,859,083.8
35430	Сэлбэг хэрэгсэл	502,000.0	309,000.0
35440	Түлш, шатах тослох материал	7,716,416.0	439,600.0
35600	Мал амьтад	21,000,000.0	49,000,000.0
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	258,500,000.0
36300	Тэжээлийн нөөц	-	258,500,000.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>724,044,183.2</u></b>	<b><u>808,100,970.4</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	724,044,183.2	808,100,970.4
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	617,704,183.1	702,280,970.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	437,505,311.0	437,505,311.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(86,349,000.3)	(95,683,562.5)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	300,844,389.0	525,844,389.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(224,447,225.5)	(362,408,108.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,627,380.8	144,504,300.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,102,244.6)	(92,766,914.3)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,294,588.4	22,294,588.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,642,463.2)	(19,347,684.3)
39214	Бусад үндсэн хөрөнгө	180,438,811.8	180,438,811.8
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,465,364.4)	(38,100,161.6)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	106,340,000.1	105,820,000.2
39301	Программ хангамж	7,000,000.0	7,000,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,259,999.9)	(6,779,999.8)
39303	Бусад биет бус хөрөнгө	105,600,000.0	105,600,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>912,096,570.5</u></b>	<b><u>1,284,542,438.2</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>911,770,704.5</u></b>	<b><u>1,284,542,438.2</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	911,770,704.5	1,284,542,438.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	723,241,635.9	723,241,635.9
51101	Өмч: - төрийн	723,241,635.9	723,241,635.9
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	530,816.7	373,302,550.4
51210	Өмнөх үеийн үр дүн	(234,519,680.8)	530,816.7
51220	Тайлант үеийн үр дүн	235,050,497.5	372,771,733.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	187,998,251.9	187,998,251.9
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>912,096,570.5</u></b>	<b><u>1,284,542,438.2</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,298,102,639.2</b>	<b>1,735,206,951.2</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>425,627,185.7</b>	<b>234,763,287.4</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>425,627,185.7</b>	<b>234,763,287.4</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	425,627,185.7	234,763,287.4
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	191,331,324.7	13,892,904.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	234,295,861.0	220,870,383.4
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>872,475,453.6</b>	<b>1,500,443,663.8</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>697,589,500.0</b>	<b>1,028,597,900.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	697,589,500.0	1,028,597,900.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>174,885,953.6</b>	<b>471,845,763.8</b>
131102	Хаагдсан данс	16,396,000.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	153,501,853.6	459,688,963.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,488,100.0	12,156,800.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,000.0	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,012,750,413.4</b>	<b>1,362,435,217.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,012,750,413.4</b>	<b>1,362,435,217.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>973,123,427.3</b>	<b>1,250,970,226.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>451,708,881.8</b>	<b>650,233,952.2</b>
210101	Үндсэн цалин	322,246,824.4	348,027,459.8
210102	Нэмэгдэл	109,912,395.3	219,217,687.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,549,662.0	32,518,759.0
210104	Урамшуулал	-	50,470,046.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>55,673,240.6</b>	<b>84,848,400.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,826,337.6	60,896,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,488,000.0	5,987,800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,590,300.0	2,993,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	897,800.0	2,993,900.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,870,803.0	11,975,900.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,811,865.3</b>	<b>19,889,341.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,039,388.5	2,240,193.8
210302	Түлш, халаалт	13,626,180.7	16,619,988.0
210303	Цэвэр, бохир ус	1,146,296.0	1,029,160.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>168,665,676.6</b>	<b>103,711,072.0</b>
210401	Бичиг хэрэг	3,783,240.0	5,742,950.0
210402	Тээвэр, шатахуун	25,239,160.0	25,449,716.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,314,443.2	2,468,776.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,139,333.4	69,809,630.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	119,760,000.0	-
210408	Бараа материал акалсны зардал	9,229,500.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,471,000.0</b>	<b>11,296,400.0</b>
210604	Урсгал засвар	2,471,000.0	10,726,500.0
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>12,552,900.0</b>	<b>19,130,900.0</b>

210702	Дотоод албан томилолт	12,552,900.0	19,130,900.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>203,583,602.0</b>	<b>286,389,196.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,518,960.0	277,699,909.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,742.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	95,800.0	138,435.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,100.0	164,252.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	110,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,800,000.0	7,640,000.0
210807	Газрын төлбөр	-	636,100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,656,261.1</b>	<b>75,376,964.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,740,800.0	1,587,250.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,915,461.1	73,789,714.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,626,986.0</b>	<b>111,464,990.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,929,100.0</b>	<b>96,987,996.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,385,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,329,100.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	90,977,996.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.0	625,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,697,886.0</b>	<b>9,476,431.0</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,616,484.9	9,476,431.0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,081,401.2	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>5,000,563.8</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,000,563.8
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>285,352,225.9</b>	<b>372,771,733.7</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>50,301,728.4</b>	<b>-</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	50,301,728.4	-
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>235,050,497.5</b>	<b>372,771,733.7</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>881,708,377.2</b>	<b>1,505,443,663.8</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>881,708,377.2</b>	<b>1,505,443,663.8</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>697,589,500.0</b>	<b>1,028,597,900.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	697,589,500.0	1,028,597,900.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>184,118,877.2</b>	<b>476,845,763.8</b>
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	16,396,000.0	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	155,770,376.0	459,688,963.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,488,100.0	12,156,800.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,464,401.2	5,000,000.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>881,708,377.2</b>	<b>1,505,443,663.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>881,708,377.2</b>	<b>1,505,443,663.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>842,081,391.2</b>	<b>1,393,978,673.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>452,544,970.7</b>	<b>650,233,952.2</b>
210101	Үндсэн цалин	292,798,811.0	348,027,459.8

210102	Нэмэгдэл	109,912,396.2	219,217,687.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,549,662.0	32,518,759.0
210104	Урамшуулал	30,284,101.5	50,470,046.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,098,200.0</b>	<b>84,848,400.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,146,500.0	60,896,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,488,000.0	5,987,800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,590,300.0	2,993,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	897,800.0	2,993,900.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,975,600.0	11,975,900.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,485,999.3</b>	<b>20,215,207.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,039,388.5	2,240,193.8
210302	Түлш, халаалт	13,300,314.7	16,945,854.0
210303	Цэвэр, бохир ус	1,146,296.0	1,029,160.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,584,043.2</b>	<b>25,197,876.0</b>
210401	Бичиг хэрэг	4,758,500.0	5,253,500.0
210402	Тээвэр, шатахуун	20,476,100.0	16,320,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,314,443.2	2,468,776.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	835,000.0	915,000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>632,000.0</b>	<b>94,000.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	632,000.0	94,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,111,800.0</b>	<b>24,603,400.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	71,000.0	14,069,900.0
210604	Урсгал засвар	9,040,800.0	10,533,500.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,456,900.0</b>	<b>15,226,900.0</b>
210702	Дотоод албан томилолт	16,456,900.0	15,226,900.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>260,563,078.0</b>	<b>571,971,687.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	255,498,436.0	563,282,400.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,742.0	
210803	Даатгалын үйлчилгээ	95,800.0	138,435.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,100.0	164,252.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	110,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,800,000.0	7,640,000.0
210807	Газрын төлбөр	-	636,100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,604,400.0</b>	<b>1,587,250.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,604,400.0	1,587,250.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,626,986.0</b>	<b>111,464,990.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,929,100.0</b>	<b>96,987,996.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		5,385,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,329,100.0	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		90,977,996.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.0	625,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,697,886.0</b>	<b>9,476,431.0</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,616,484.9	9,476,431.0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,081,401.2	5,000,563.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Аудитлагдсан үлдэгдэл			
		Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	793,641,635.9	187,998,251.9	(230,826,367.8)	750,813,520.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,693,313.0)	(3,693,313.0)
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>793,641,635.9</b>	<b>187,998,251.9</b>	<b>(234,519,680.8)</b>	747,120,207.0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(70,400,000.0)	-	-	(70,400,000.0)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	235,050,497.5	235,050,497.5
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,241,635.9	187,998,251.9	530,816.7	911,770,704.5
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>723,241,635.9</b>	<b>187,998,251.9</b>	<b>530,816.7</b>	911,770,704.5
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	372,771,733.7	372,771,733.7
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,241,635.9	187,998,251.9	373,302,550.4	1,284,542,438.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,028,597,900.0</b>	<b>1,019,121,469.0</b>	<b>(9,476,431.0)</b>	<b>99.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,028,597,900.0</b>	<b>1,028,597,900.0</b>	-	<b>99.1</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>931,520,500.0</b>	<b>922,133,473.0</b>	<b>(9,387,027.0)</b>	<b>99.1</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>658,287,300.0</b>	<b>650,233,952.2</b>	<b>(8,053,347.8)</b>	<b>99.1</b>
210101	Үндсэн цалин	372,802,900.0	348,027,459.8	(24,775,440.2)	99.1
210102	Нэмэгдэл	247,051,900.0	219,217,687.4	(27,834,212.7)	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,893,400.0	32,518,759.0	14,625,359.0	99.0
210104	Урамшуулал	20,539,100.0	50,470,046.1	29,930,946.1	98.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,848,400.0</b>	<b>84,848,400.0</b>	-	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,896,900.0	60,896,900.0	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,987,800.0	5,987,800.0	-	99.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,993,900.0	2,993,900.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,993,900.0	2,993,900.0	-	99.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,975,900.0	11,975,900.0	-	98.8
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,792,800.0</b>	<b>20,215,207.7</b>	<b>(577,592.3)</b>	<b>97.2</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,016,400.0	2,240,193.8	223,793.8	111.1
210302	Түлш, халаалт	17,690,300.0	16,945,854.0	(744,446.1)	99.1
210303	Цэвэр, бохир ус	1,086,100.0	1,029,160.0	(56,940.0)	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,585,600.0</b>	<b>25,197,876.0</b>	<b>(387,724.0)</b>	<b>98.5</b>
210401	Бичиг хэрэг	5,253,700.0	5,253,500.0	(200.0)	100.0

210402	Тээвэр, шатахуун	16,321,000.0	16,320,600.0	(400.0)	99.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,495,800.0	2,468,776.0	(27,024.0)	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.0	240,000.0	(360,000.0)	99.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	915,100.0	915,000.0	(100.0)	98.8
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>94,100.0</b>	<b>94,000.0</b>	<b>(100.0)</b>	<b>99.9</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	94,100.0	94,000.0	(100.0)	99.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,611,900.0</b>	<b>24,603,400.0</b>	<b>(8,500.0)</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,069,900.0	14,069,900.0	-	100.0
210604	Урсгал засвар	10,542,000.0	10,533,500.0	(8,500.0)	99.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,226,900.0</b>	<b>15,226,900.0</b>	-	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	15,226,900.0	15,226,900.0	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>100,482,500.0</b>	<b>100,126,487.0</b>	<b>(356,013.0)</b>	<b>99.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,450,200.0	91,437,200.0	(13,000.0)	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	194,000.0	138,435.0	(55,565.0)	99.1
210803	Даатгалын үйлчилгээ	236,700.0	164,252.0	(72,448.0)	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,500.0	110,500.0	(7,000.0)	99.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,848,000.0	7,640,000.0	(208,000.0)	93.4
210807	Газрын төлбөр	636,100.0	636,100.0	-	88.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,591,000.0</b>	<b>1,587,250.0</b>	<b>(3,750.0)</b>	<b>99.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,591,000.0	1,587,250.0	(3,750.0)	99.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,077,400.0</b>	<b>106,464,427.0</b>	<b>9,387,027.0</b>	<b>109.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>97,077,400.0</b>	<b>96,987,996.0</b>	<b>(89,404.0)</b>	<b>99.9</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.0	5,385,000.0	(15,000.0)	99.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,050,000.0	90,977,996.0	(72,004.0)	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	627,400.0	625,000.0	(2,400.0)	99.1
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,028,597,900.0</b>	<b>1,019,121,468.98</b>	-	<b>99.1</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,028,597,900.0</b>	<b>1,019,121,468.98</b>	-	<b>99.1</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,028,597,900.0	1,019,121,468.98	9,476,431.02	99.1
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>49.0</b>	<b>49.0</b>	-	<b>100.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	-	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>24.0</b>	<b>24.0</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.0	18.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.0	5.0	-	100.0

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>476,845,763.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	476,845,763.8
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	471,845,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	471,845,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		471,845,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	5,000,563.80
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	5,000,563.80
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,000,563.80
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>476,845,763.8</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	476,845,763.80
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	459,688,963.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,156,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,000,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 22,981.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 22,317.6 мянган төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлыг 663.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт 22,981.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 15,744.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15,744.9 мянган төгрөгийн 7 зөрчил илэрч, 15,744.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.


### 3.2 Албан шаардлага

1. Иргэдэд үр тарааж 8,892.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй /аудит хийх хугацаанд 3,000.0 мянган төгрөгийг тус байгууллагын дансанд төвлөрүүлсэн/ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэдэд тараасан үрийн төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд 3,500.0 мянган төгрөгийн багаж хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдах авахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Даргын тушаалаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд урамшууллыг олгохдоо 660.0 мянган төгрөгийг дутуу олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа. 61.1.Төрийн албан хаагч дараах нийтлэг баталгаагаар хангагдана: 61.1.9.ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Даргын тушаалаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд урамшууллын дутууг нөхөн олгох албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудал


Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвийн хөрөнгийг аймгийн Засаг даргын захирамжаар эрх шилжүүлээгүй байхад, АЗДТГ-аас санхүүжилтийг шилжүүлж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас малчдад хүнсний багц хүргэх, зудтай холбоотойгоор өвөлжилтийн нөхцөл хүндэрч зам хаагдсан сумуудын зам нээх, цасанд дарагдсан малчдын хашаа хорооны цасыг түрэх, Газар тариалан эрхлэгчдэд ухаалаг программ сургалт хийсэн, ногоон байгууламж, Заг ховор ургамлын үр, модны суулгац худалдан авах, өвс, тэжээл бэлтгэх арга хэмжээнд 476,845.8 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", "Хүргэлт-V" арга хэмжээний Ажил гүйцэтгэх гэрээ"-нүүдийн Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг: 4.6 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах үүрэгтэй. Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг: 5.3-т Ажлын явцыг захиалагчийн хүсэлт, ажлын даалгаварт заасны дагуу тухай бүр танилцуулна. "Нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажил гүйцэтгэх гэрээ"-ний Гурав. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг 2 тал тухай бүр харилцан тохирч шийдвэрлэнэ. гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна"

Өгсөн зөвлөмж: Эрх шилжүүлээгүй нэмэлт санхүүжилтийн дансаарх орлогыг зарцуулахгүй байх, хууль, журмыг үнэн зөв мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье



Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(мянган төгрөг)

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хүнс, хөдөө аж ахуйн газар	Санхүүгийн үр дүнгийн тайланд Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 22,317.6 мянган төгрөгөөр, Хангамж, бараа материалын зардлыг 663.9 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт 22,981.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	22,981.5	-	-	1	22,981.5	1	22,981.5	-	-	-	-
	<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>22,981.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>22,981.5</b>	<b>1</b>	<b>22,981.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



(мянган төгрөг)

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:														
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн								
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12							
	Иргэдэд үр тарааж 8,892.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, аудитын хийх хугацаанд 3,000.0 мянган төгрөгийг тус байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна.	1	5,892.9	-	-	1	5,892.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Тайлант онд 3,500.0 мянган төгрөгийн багаж хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	3,500.0	-	-	1	3,500.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хүнс, хөдөө аж ахуйн газар	Батлагдсан бүтэц орон тоонд архив, бичиг хэрэг, нярав хариуцсан мэргэжилтэн 1 орон тоогоор батлагдсан байхад нярвын ажлыг өөр албан тушаалтанд хавсран гүйцэтгүүлж 2,026.0 мянган төгрөг, сантехникийн ажлыг хавсран гүйцэтгүүлж 3,666.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин тус тус олгосон.	1	5,692.0	-	-	1	5,692.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Даргын тушаалаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд урамшууллыг олгохдоо 660.0 мянган төгрөгийг дутуу олгосон байна.	1	660.0	-	-	1	660.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>15,744.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>15,744.9</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
	Өвс, тэжээлийн нөөцөөс аймгийн Засаг даргын захирамжгүйгээр 27,800,0 мянган төгрөгийн 2000 боодол өвсийг Бугат сумын ГИДЦГ-ын Б хэсгийн захиргаанд шилжүүлэн өгсөн байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-		
	Иргэдэд 6 нэр төрлийн 59,080.2 мянган төгрөгийн бараа материал, 7 нэр төрлийн 219,389.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглуулж байгаа гэх боловч ашиглалтын гэрээ байгуулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-		
Хүнс, хөдөө аж ахуйн газар	Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвийн хөрөнгийг аймгийн Засаг даргын захирамжаар эрх шилжүүлээгүй байхад, ТЗДТГ-аас санхүүжилтийг шилжүүлж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас малчдад хүнсний багц хүргэх, зудтай холбоотойгоор өвөлжилтийн нөхцөл хүндэрч зам хаагдсан сумуудын зам нээх, цасанд дарагдсан малчдын хашаа хорооны цасыг түрэх, Газар тариалан эрхлэгчдэд ухаалаг программ сургалт хийсэн, ногоон байгууламж, Заг ховор ургамлын үр, модны суулгац худалдан авах, өвс, тэжээл бэлтгэх арга хэмжээнд 476,845.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-		
	<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>				